



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 10 өдөр Дугаар 14

Хэрлэн сум

XIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын XIV хурал 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 09:30 цагт аймгийн Засаг даргын хуралдааны танхимд 86 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Монгол Улсад шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын анхны тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан үүссэн нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа:

2. Хот, аймаг, сум хоорондын автотээврийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах тухай.

3. Тус аймгаас ОХУ-ын Чита хотод албан ажлаар зорчсон 16 иргэнийг гэрээр тусгаарлан ажиглах тухай Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа:

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт

1.1. Монгол Улсын Онцгой комиссын 2020 оны 05 дугаар тогтоолын дагуу нийслэл, аймаг сумаас гарах хот хооронд зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07:00 цагаас 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэл түр зогсоох арга хэмжээг авч ажиллахыг,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад

2.1. 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр агаарын тээврээр Испани улсаас ирсэн иргэн Б.Оргил-Эрдэнэ, 2020 оны 03 дугаар сарын 07-ны өдөр АНУ-аас ирсэн

Г.Олзвой нарыг 14 хоногийн хугацаанд тусгаарлах байрт тусгаарлаж эрүүл мэндийн тандалт хийхийг,

Гурав. Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа Б.Бямбаа, Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт

3.1 ОХУ-ын Чита хотод албан ажлаар зорчсон 16 иргэний овог нэр, оршин суугаа хаяг, ажлын газрыг тогтоож, бүртгэл судалгааг гаргаж Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлэхийг,

Дөрөв. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт

4.1 ОХУ-ын Чита хотод албан ажлаар зорчсон 16 иргэнийг гэрээр тусгаарлан ажиглах, танилцуулах хуудас, албан мэдэгдлийг өгч баталгаа гаргуулахыг,

Тав. Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа Б.Бямбаад

5.1 Дорнод аймгийн иргэдээс 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс хойш Дорноговь аймгийн Замын-Үүд чиглэлд зорчсон иргэдийн тандалт судалгааг гаргаж танилцуулахыг,


Зургаа. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Гадаадын иргэн, харъяатын газрын Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир нарт:


6.1 Бусад улсаас ирсэн Дорнод аймгийн харъяат иргэдийн мэдээллийг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газарт албан бичгээр ирүүлэх, "Telegram" аппликейшнд мэдээллийг байршуулахыг,

Долоо. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад,

7.1. Аймгийн Онцгой комиссыг цомхотгосон хэлбэрээр хуралдуулах саналыг дараагийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг,

7.2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зарцуулах журмын төслийг Онцгой комиссын хурлаар хэлэлцүүлж урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж эхлэх шийдвэр гаргуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА